

**ХОВД АЙМГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024.12.10

Ховд хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО,
ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ
Нийтлэг үндэслэл.**

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлэх, зарим шалгуур үзүүлэлтүүдийн талаар нэмэлт мэдээлэл, тоо баримт авах зэргээр үнэлгээ хийв.

Ховд аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны Стратеги төлөвлөгөөг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2.2, 6.2.3-д заасан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх аргачлалын дагуу, шалгуур үзүүлэлт тус бүрийн хүрсэн түвшин, гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан үнэлгээ өгч тооцон гаргав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:

Ховд аймгийн Биеийн тамир, спортын газрын Стратеги төлөвлөгөөнд хамаарах 7 зорилтын 27 арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэл, зохион байгуулалт, хариуцлагын тогтолцоог сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

Ховд аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж ажиллав.


Ингэхдээ Биеийн тамир спортын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд хийсэн ажлын тайлантай танилцах, судлах түүнд хавсарсан мэдээ, мэдээллийг ашиглан хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Стратеги төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 27 арга хэмжээнээс "үр дүнтэй" буюу 100 хувийн хэрэгжилттэй 21, "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 90 хувийн хэрэгжилттэй 4, 70 хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ дунджаар 91.4 хувьтай дүгнэгдлээ.

График 1

Арга хэмжээ тус бүрээр



Хүснэгт 1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн (2024 оны жилийн эцсийн байдлаар)

№	Ажил үйлчилгээ	Арга	Үнэлгээ (хувиар)					Дундаж үнэлгээ	
			0	30	50	70	90		100
1	Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн туншлалд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ	4	-	-	-	1	2	1	65
2	Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт зам талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина, засварлана.	6	-	-	-	1	-	5	95
3	Спортын сургалтдасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах	10	-	-	-	-	-	10	100
4	Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах	3	-	-	-	-	-	3	100
5	Биеийн тамир, спортын салбар гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх	2	-	-	-	-	-	2	100
6	Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж, дүгнэлтээр хангах, хяналт тавих	1	-	-	-	-	1	-	90
7	Биеийн тамир, спортын салбарын хэмжээнд дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэн сайжруулах	1	-	-	-	-	1	-	90
Нэгдсэн дүн		27	-	-	-	2	4	21	91.4

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тус гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгтгэн дүгнэлээ.

Биеийн тамир, спортын газрын 2021-2024 оны Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 91.4 хувьтай үнэлэгдсэн нь төлөвлөсөн ажил үйлчилгээ, арга хэмжээнүүд нь “үр дүнтэй” буюу зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ (ЗӨВЛӨМЖ)

Стратеги төлөвлөгөөний заалтуудыг хяналтад авч цаашид авах арга хэмжээ, бодлогыг тодорхойлох үүрэг хүлээсэн байгууллага, нэгжид дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулан дүгнэлт өгч, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хүрэх түвшинтэй уялдуулан, ямар үр нөлөө үзүүлснийг тодорхой, тоо баримттай, статистикийн мэдээнд үндэслэн үнэн бодитой, санхүүжилтийн гүйцэтгэл, эх үүсвэрийг арга хэмжээ бүрээр бүрэн тайлагнаж байх
2. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, удирдлага зохион байгуулалтыг сайжруулж, хэрэгжилтийг үр дүнд чиглүүлэн зохион байгуулж тайлагнах
3. Хуулиар болон гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, гэрээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт тайлагналтыг сайжруулахад анхаарч ажиллах

ГАЗРЫН ДАРГА

ТАНИЛЦСАН:

Ч.ТҮМЭНДЭМБЭРЭЛ



ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
МЭРГЭЖИЛТЭН

Ц.СЭР-ОД



Г АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗАРТ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 55,
Утас: 262449, 266246 Факс: (976-11) 32 52 34
И-мэйл: info@sport.gov.mn


2025. 01. 14 № 1/24
танай _____ -ны № _____ -т

Г Тайлан хүргүүлэх тухай Г

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичиг болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсралтаар хүргүүлж байна. Тайланд тусгасан зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллана уу.

Хавсралт ... хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТУ
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГ



О.БАТТУЛГА

ХОВД АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025.01.13

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Ховд аймгийн биеийн тамир, спортын газрын 2024 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 4.7-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгов.

Ховд аймгийн биеийн тамир, спортын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 45 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг жилийн эцсийн зорилтот түвшин, үр дүнтэй харьцуулан үнэлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ыг тус тус баримтлав.

Гурав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Ховд аймгийн биеийн тамир, спортын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явц 3 зорилтын хүрээнд 45 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулж 32 арга хэмжээ "үр дүнтэй" буюу 100 хувь, 9 арга хэмжээ "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70-99 хүртэл хувь, 2 арга хэмжээ "эрчимжүүлэх шаардлагатай" 31 – 69 хүртэл хувь, 2 арга хэмжээ "үр дүнгүй" буюу 0-30 хүртэл хувьтай тус тус үнэлэгдэж биелэлтийн дундаж **91,4** хувьтай буюу "тодорхой үр дүнд хүрсэн" байна.

2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн үнэлгээний задаргаа

№	Дэс дугаар	Зорилт, арга хэмжээ	ХАБТСГ Үйцэтгэл ийн хувь	БТСУХ Үнэлгээ
Биеийн тамирын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжируулах/ нөхцөлийг бүрдүүлж олон нийтэд хүртээмжтэй болгох				
Зорилт 1				89,2%
Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжируулах				
1	1.1	Арга хэмжээ 1: Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилыг хугацаанд нь авч шивэх	100%	90%
	1.2	Арга хэмжээ 2 Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх	70%	60%
	1.3	Арга хэмжээ 3 Байгууллагын мэдээллийн цахим санг бүрдүүлж зарим мэдээллийг цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.	100%	100%
	1.4	Арга хэмжээ 4 Биеийн тамир, спортын холбоодын мэдээллийг цахим санд бүртгэн мэдээллийг байршуулах /холбоод, клубын мэдээлэл/	90%	80%
	1.5	Арга хэмжээ 5 Алтай, Зэрэг, Цэцэг, Дарви сум, Жаргалант сумын Бугат багийн спорт заалыг ашиглалтад оруулах	70%	50%
	1.6	Арга хэмжээ 6 Ахмад настны спортын үйл ажиллагаанд хамруулах, дэмжлэг үзүүлэх	100%	100%
	1.7	Арга хэмжээ 7 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, дэмжлэг үзүүлэх	100%	100%
	1.8	Арга хэмжээ 8 Өртөөт марафон -2024 Бүх нийтийн арга хэмжээг зохион байгуулах	100%	90%
	1.9	Арга хэмжээ 9 Нийтийн биеийн тамирын Өглөөлөг-Ховдчууд аян зохион байгуулах	100%	100%
	1.10	Арга хэмжээ 10 “Иргэдийн наадам” биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах	100%	100%
	1.11	Арга хэмжээ 11 “Хөгжөөнт буухиа “ биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах	100%	90%
	1.12	Арга хэмжээ 12 Тамирчдын баярын үйл ажиллагааг зохион байгуулах	100%	100%
	1.13	Арга хэмжээ 13 Мөнгөлөг шагшуурга цас мөсний баярын спортын арга хэмжээг зохион байгуулах	100%	100%
Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, өсвөрийн шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг бүс, улс, олон улс, тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх				
Зорилт 2:		Спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан өсвөр үеийн шигшээ багийн тамирчдын спортын амжилтыг улс, олон улс, тив, дэлхийн түвшинд хүргэх		83,4%
	2.1	Арга хэмжээ 1 Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг байгуулж, залгамж халааг сайжруулах, шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлэх	100%	100%
	2.2	Арга хэмжээ 2 Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах	100%	100%
		Арга хэмжээ 3		

2		аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг жил тутам зохион явуулах, зохион байгуулалтыг оновчтой болгох		
	2.4	Арга хэмжээ 4 Шинэ тутам хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	100%	100%
	2.5	Арга хэмжээ 5 Биеийн тамир, спортын ажил үйлчилгээний хүн амд үзүүлэх нэр төрлийг багийн спортын төрлөөр нэмэгдүүлж, орон нутагт хамрах хүрээг тэлэх	100%	100%
	2.6	Арга хэмжээ 6 Улс, бүсийн тэмцээнд баг тамирчдыг амжилттай бэлтгэн оролцуулах	100%	100%
	2.7	Арга хэмжээ 7 Аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулах	100%	95%
	2.8	Арга хэмжээ 8 Өвлийн спортын их наадамд оролцох /БНХАУ-ын Шинжаан Уйгар/	100%	90%
	2.9	Арга хэмжээ 9 Байт харвааны улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	-	0%
	2.10	Арга хэмжээ 10 Хөлбөмбөгийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	-	0%
	2.11	Арга хэмжээ 11 Байт харвааны баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	100%	100%
	2.12	Арга хэмжээ 12 Чөлөөт бөхийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	100%	100%
2.13	Арга хэмжээ 13 Спортын байгууллагын баруун бүсийн уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулах	100%	100%	
Зорилт-3: Биеийн тамир, спортын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон төрөөс биеийн тамир, спортын талаар баримталж буй бодлого шийдвэрийг ханган мөрдөнө.				98,4%
3	3.1	Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах	90%	90%
	3.2	Арга хэмжээ 2 Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад мөнгөн шагнал олгох, олимпын наадам, дэлхийн аварга, тив, улсын аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчин, дасгалжуулагчдад аймгаас урамшуулал олгох	100%	100%
	3.3	Арга хэмжээ 3 Спортын аварга хөтөлбөрийг хэрэгжүүлэх	100%	100%
	3.4	Арга хэмжээ 4 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэн, үнэлж дүгнэнэ.	100%	100%
	3.5	Арга хэмжээ 5 Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангаж, явц үр дүнг тайлагнах	100%	100%
	3.6	Арга хэмжээ 6 Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, албан хаагчдын ажиллах нөхцөл, чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах	100%	100%
	3.7	Арга хэмжээ 7 Монгол хэл, бичгийг анхан шатны сургалтанд байгууллага хамт олны хамруулах	100%	100%
	3.8	Арга хэмжээ 8 Улсын хэмжээнд мөрдөж байгаа спортын тэмцээн, наадмын зохион байгуулалтын журам, норм, норматив, стандартыг мөрдүүлэх, орон нутгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, удирдамж арга зүйн зөвлөмж хүргүүлэх	100%	90%

	“Стандарттай Ховд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнана.		90%
3.11	Арга хэмжээ 11 Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө боловсруулан батлаж ажиллана.	100%	100%
3.12	Арга хэмжээ 12 Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллана.	100%	100%
3.13	Арга хэмжээ 13 Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд оролцох цаг үеийн үүрэг хэрэгжүүлж ажиллана.	100%	100%
3.14	Арга хэмжээ 14 E-Mongolia дотоод удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлнэ.	100%	100%
3.15	Арга хэмжээ 15 Санхүүгийн сахилга хариуцлага дээшлүүлэн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангана.	100%	100%
3.16	Арга хэмжээ 16 Байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, хуулийн хугацаанд шуурхай хариу өгч ажиллана	100%	100%
3.17	Арга хэмжээ 17 Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, худалдан авах ажиллагаа, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж нээлттэй мэдээлж ажиллана.	100%	100%
3.18	Арга хэмжээ 18 Байгууллагын жендерийн тэгш байдлыг хангаж ажиллана.	100%	100%
3.19	Арга хэмжээ 19 Авилгатай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.	100%	100%
Биелэлтийн дундаж хувь			91,4%

Дөрөв. Дүгнэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, биелэлтэд үнэлгээ өгөх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэх, гарсан алдаа, дутагдлыг арилгах, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглэдэг билээ. Ховд аймгийн биеийн тамир, спортын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийн дундаж **91,4** хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна. Төлөвлөгөөнд туссан зарим арга хэмжээний биелэлт, тайлагналт хангалтгүй байна. Тухайлбал хэрэгжүүлсэн арга хэмжээний тушаал, шийдвэр, удирдамжийн дугаар, огноо байхгүй байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3 зорилт бүхий 45 арга хэмжээнээс 32 арга хэмжээ нь 100 хувь буюу “үр дүнтэй” хэрэгжсэн байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зарим арга хэмжээг оновчтой тодорхойлоогүй, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг холбогдох журам, аргачлалын дагуу тодорхой, хэмжигдэхүйц байдлаар томъёолоогүй зөрчил дутагдал байна.

Арга хэмжээ 1.2 “Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх”, “Алтай, Зэрэг, Цэцэг, Дарви сум, Жаргалант сумын Бугат багийн спорт заалыг ашиглалтад оруулах” зэрэг арга хэмжээ тайлагналт хангалтгүй, зорилгот түвшиндээ хүрч ажиллаагүй байна.

Арга хэмжээ 2.9 “Байт харвааны улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах”, 2.10 “Хөлбөмбөгийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах” зэрэг арга хэмжээ хэрэгжилт үр дүнгүй, хэрэгжээгүй шалтгаан нөхцөлийг тайлагнаагүй алдаа дутагдал харагдаж байна.

Тав. Зөвлөмж: Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Бүх албан хаагчдад:

2. Тухайн төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолох, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллах, хэрэгжээгүй тохиолдолд шалтгаан нөхцлийг тодорхой тайлагнаж байх,

Удирдлагуудад:

1. Арга хэмжээ 1.2 "Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлэх", "Алтай, Зэрэг, Цэцэг, Дарви сум, Жаргалант сумын Бугат багийн спорт заалыг ашиглалтад оруулах" зэрэг арга хэмжээг тус тус 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг зорилгот түвшинд хүргэж ажиллах,

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах,

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, тухайн жилийн зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, суурь түшинг тооцоо судалгаанд үндэслэн бодитой тодорхой тусгасан шаардлага хангасан тайланг нэгтгэх мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг тус тус зөвлөмж хүргүүлж байна.

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан "Аргачлал, загвар батлах тухай" тушаалыг тус тус мөрдөж, төлөвлөлтийг сайжруулахад анхааран ажиллана уу. Та бүхэнд амжилт хүсье.

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

ХЯНАСАН:

ХШУДАХ-ИЙН ДАРГА

Н.БАТСҮХ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХШУДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН *С. Уранбилэг* Д.УРАНБИЛИГ